



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн  
Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, 3.7.1, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн  
дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,

Гишүүд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга,  
Аймгийн Ерөнхий прокурор,  
Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор  
Аймгийн Цагдаагийн газрын дарга,  
Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга,  
Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга,  
Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга,  
Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга,  
Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга.

Салбар зөвлөлийн  
нарийн бичгийн  
дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн  
захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, тогтоол  
шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн.


2.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангахыг Ажлын алба /Д.Баатарсайхан/-нд, салбар зөвлөлийн

хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад тус тус даалгасугай.

3.Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 154 дүгээр тогтоолыг 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ЦОГОО